

Уриалга

Бид монголын сэтгүүл зүйн арвин баялаг түүх уламжлал, ахмад үеэрээ бахархдаг ирээдүйн сэтгүүлч билээ.

Бид ардчилсан Монголд чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийн анхны шанг татаж, хэвлэлийн эрх чөлөөний үр суулган цэцэглүүлсэн, цог жавхаат шинэчлэгчдээр бахархдаг ирээдүйн сэтгүүлч билээ.

Бид, эрх чөлөө хэмээх сүрлэг их далайд сэтгүүл зүй хэмээх аварга хөлгийн жолоог атгаж, бэрхшээл сорилыг даван туулж яваа өнөөгийн сэтгүүлчдийн залгамж халаа билээ.

Бид хорь хүрээгүй идэр залуу насандаа алдаж онож яваа, чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийн салбарт бүл нэмж, ардчилсан, хариуцлагатай, олон ургальч, ёс зүйт сэтгүүл зүйн хөгжилд хувь нэмэр оруулах ирээдүйн сэтгүүлч билээ.

Бид халуун сэтгэл, хатуу шаардлага хосолсон, редакцийн гал тогоонд чанагдан боловсрох ирээдүйн сэтгүүлч билээ.

Бид урмаар сэргэж, итгэлээр жигүүрлэн, амьдралын гараагаа эхэлж, амжилт өөд тэмүүлэх ирээдүйн сэтгүүлч билээ.

Бид өнөөдөр монголын хэвлэл мэдээлэлд тулгамдсан асуудал болж буй улс төрийн, эдийн засгийн хүчирхийлэл, хуулиар хориглосон ч амь бөхтэй оршсоор байгаа бүх төрлийн цензурыг эсэргүүцэж байна.

Сэтгүүл зүйн оюутан бид олон нийтийн хоточ нохой байж, зөвхөн үнэнийг хэлэхийн төлөө сэтгэл зүрхээ зориулан ажиллахын төлөө бэлэн байна. Гэхдээ бидний мэргэжлийн эрхээ эдлэх, ажиллах хөдөлмөрлөх нөхцөл ЭЭЛТЭЙ байгаасай гэж хүсч байна.

Шинэ үеийн сэтгүүлч бид шударга сэтгүүл зүйг эрхэмлэн хүсэмжилж уриалга гаргаж байна

Ирээдүйн сэтгүүлч бид:

1. Олон нийтийг үнэн, бодитой, тэнцвэрт мэдээллээр хангах үйл явцад саад тотгор учруулж буй хууль тогтоомжийг шинэчилж, шаардлагатай хуулийг шинээр батлаасай
2. Сэтгүүлчийн ёс зүйн зарчмаа мөрдөх механизм бий болгож, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг хөгжүүлээсэй
3. Хараат бус байдлаар ажил хөдөлмөрөө эрхлэх боломж, нөхцөлийг редакцид бүрдүүлж, залуу сэтгүүлчдийг дэмжин халамжилж байгаасай гэж хүсэж байна.

Үзэг хурц, үг үнэн, сэтгэл шулуун, санаа шударгуу байхын төлөө та бүхнийг уриалж байна. Хүлээн авна уу.